



МОНГОЛ УЛС  
ХОВД АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ

2021 оны 05 сарын 10 өдөр

Дугаар А/225

Ховд

Хөрөнгө гаргах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.1.а, 29.1.4 дэх заалт, Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.3 дахь заалт, аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2020 оны 12 дугаар сарын 03-ны өдрийн гуравдугаар хуралдааны 3/03 дугаар төсөв батлах тухай тогтоолын 6 дугаар хавсралтын 5.10 дахь заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Шинэ Ховд Баруун Бүсийн Хөгжлийн Корпораци орон нутгийн өмчит, аж ахуйн тооцоот үйлдвэрийн газрын үйл ажиллагааны зардалд (Иноваци, технологийг нэвтрүүлэх) 50.000.000 төгрөгийг хавсралтаар баталж зарцуулсугай.

2. Дээрх арга хэмжээнүүдэд зарцуулах 50.000.000 төгрөг /Тавин сая төгрөг/-ийг Хөшөөт Хөгжил сангийн хөрөнгөөр 2021 онд хэрэгжүүлэх хөрөнгө оруулалт, хөтөлбөр, арга хэмжээний жагсаалтын 5.10 дахь заалтаас санхүүжүүлэхийг Санхүү, төрийн сангийн хэлтсийн дарга /Ч.Багдал/, Хөрөнгө оруулалт, хөгжлийн бодлого, төлөвлөлтийн хэлтсийн дарга /Б.Баярсүх/ нарт зөвшөөрсүгэй.

3. Захирамжийн хэрэгжилтэнд хяналт тавьж ажиллахыг Засаг даргын орлогч /Т.Жаргалсайхан/-д үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГА



Б.ДҮГЭРЖАВ

Аймгийн Засаг даргын 2021 оны 05 дугаар  
сарын 10 -ны өдрийн А/ 225 дугаар  
захирамжийн хавсралт



ЗАРДЛЫН ТӨСӨВ

Д.д	Зардлын нэр төрөл, утга	Нэгж	дүн
1	Цалингийн зардал	1-12сар	40000000
2	Үйл ажиллагааны бусад зардал	4сар	10000000
	ДҮН		50000000

-oOo-